

**НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД САНХҮҮЖИХ ХҮН АМ,  
МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ  
ЗОРИЛГООР НИЙСЛЭЛД ШИНЭЭР БАРИГДАХ ИНЖЕНЕРИЙН  
ХИЙЦТЭЙ ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

*Тендер шалгаруулалтын дугаар:* НХААГ-14/0097

**2014 он**

## ТАЙЛАН

Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дугаар захирамжын 2 дугаар хавсралтаар байгуулагдсан “Нийслэлд шинээр баригдах инженерийн хийцтэй худаг гаргах ажил”-ын Үнэлгээний хороо нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Дээрхи тушаалаар батлагдсан Үнэлгээний хороо нь 2014 оны 03 дугаар 24-ний өдөр тус ажлын тендерийн зарлалыг товлосон.
2. 2014 оны 03 дугаар сарын 24-ны өдөр өдөр тутмын сонин “Өдрийн сонин”, “Нийслэл таймс” сонин, “Ардчилал” сонин, Худалдан авах ажиллагааны газрын [ub-procurement.mn](http://ub-procurement.mn), [e-procurement.mn](http://e-procurement.mn), Нийслэлийн [ulaanbaatar.mn](http://ulaanbaatar.mn) сайтуудад зарласан.
3. 2014 оны 03 дугаар сарын 24-нөөс 04 дүгээр сарын 23-ныг хүртэл тендерийн материалыг худалдсан. Нийт 13 компани тендерийн материал худалдан авсан.
4. 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө тендерийн материал худалдан авсан компаниудаас 7 компани тендер ирүүлсэн. Үүнд:
  1. ТЭНХЛЭГ УС ХХК
  2. МОНТЕГЕО ХХК
  3. ГАЗРЫН ГҮНИЙ УС ХХК
  4. БУЯН УС ХХК
  5. ЭРДЭНЭ ДРИЙЛИНГ ХХК
  6. УС АЛМАЗ ХХК
  7. МОНГЕОФИЗИК ХХК
5. Тендерийн нээлт 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутанд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 201 тоот өрөөнд болсон.
6. Техникийн саналыг үнэлэх хурлыг 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хийж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын баталсан тендер шалгаруулах журам, тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдлыг харгалзан техникийн саналыг үнэлэв.

## Техникийн үнэлгээ хийсэн тухай

Тендерийн үнэлгээ хийсэн Техникийн саналын үнэлгээний маягтын дагуу үнэлж хавсаргав.

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТОВЧ АГУУЛГА

1. Захиалагч	
1.1 Нэр	Нийслэлийн Үйлдвэр Хөдөө аж ахуйн газар
1.2 Хаяг	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Нийслэлийн Захиргааны Хангарьд ордон, 4 давхар
2. Хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан шийдвэр	Улсын төсвийн хөрөнгөөр
3. Төсөл хэрэгжих хугацаа /эх үүсвэр хүчинтэй байх хугацаа/	Улсын төсөв, 2014 он
4. Төслийн нэр, дугаар	“Нийслэлд шинээр баригдах инженерийн хийцтэй худаг гаргах ажил” НХААГ-14/0097
5. Гэрээний дугаар	
6. Гэрээний нэр	“Нийслэлд шинээр баригдах инженерийн хийцтэй худаг гаргах ажил”
7. Гэрээний товч агуулга	
8. Төсөвт өртөг	178.500.000 төгрөг
9. Гүйцэтгэгч сонгох ажиллагааны журам	Ажлын нээлттэй тендер шалгаруулалт
10. Захиалагч эсхүл эрх бүхий байгууллагаар урьдчилан хянуулах шаардлагатай эсэх	Тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулан тендерийг зарласан.
11. Дотоодын давуу эрхийн зөрүүг хэрэглэх	Тийм
12. Тогтмол үнийн гэрээ	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
13. Санхүүжилтийн бусад эх үүсвэр байгаа бол:	Байхгүй.
(1) Хамтран санхүүжүүлэгчийн нэр	
(2) Хамтран санхүүжүүлэх хувь	

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЯВЦ

1. Төслийг	2014 он
(а) анх баталсан огноо	2014 он
(б) хамгийн сүүлд өөрчилж баталсан огноо	-
2. Урьдчилсан сонголт (шаардлагатай бол)	-
(а) урьдчилсан сонголтод тэнцсэн хуулийн этгээдийн тоо	-
(б) урьдчилсан сонголтын дүнг баталсан огноо	Өдрийн сонин, Нийслэл таймс, Ардчилал сонин
3. Урилгыг зарлаж мэдээлсэн	
(а) өдөр тутмын сонины нэр	2014-03-24
(б) хэвлэгдсэн огноо	<a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a> , <a href="http://ubprocurement.mn">ubprocurement.mn</a> , <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a>
(в) бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	- Үгүй
(г) олон улсын хэмжээний, эсхүл олон улсын хэл дээр хэвлэгддэг хэвлэл, мэдээллийн нэр	-
(д) хэвлэгдсэн огноо	-
(е) урилга илгээсэн этгээдийн тоо	-
(ё) урилга илгээсэн огноо	“Нийслэлд шинээр баригдах инженерийн хийцтэй худаг гаргах ажил” НХААГ-14/0097
4. Тендерийн баримт бичиг	
(а) нэр, хэвлэсэн огноо	
(б) баталсан огноо	2014-03-24 2014-04-23
(в) тендерт оролцогчдод тараасан хугацаа	13
5. Тендерийн баримт бичгийг авсан хуулийн этгээдийн тоо	- Үгүй
6. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан бол	- Үгүй
(а) огноо (бүгдийг жагсаана уу)	- Үгүй
(б) баталсан огноо	Үгүй
7. Тендер шалгаруулалтын өмнөх уулзалт хийсэн бол, огноо	Үгүй
8. Тендер шалгаруулалтын өмнөх уулзалтын хийсэн бол тэмдэглэлийг тендерт оролцогчдод тараасан огноо	

## ТЕНДЕРИЙГ ХҮЛЭЭН АВАХ БОЛОН НЭЭХ

1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	
(а) анхны огноо, цаг	2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минут
(б) сунгасан огноо (хэрэв сунгасан бол)	Үгүй
2. Тендерийг нээх огноо, цаг	2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минут
3. Ирсэн тендерийн тоо	7
4. Тендер хүчинтэй байх хугацаа (хоногоор)	Тендер нээснээс хойш 45 хоног
(а) анхны тогтоосон хугацаа	45
(б) сунгасан хугацаа (хэрэв сунгасан бол)	Үгүй
(в) сунгалтыг үнэлгээний хорооноос баталсан огноо (шаардлагатай бол)	Үгүй

## ТЕНДЕР ШАЛГАРСАН БАЙДАЛ

1	тендерийн нэр	Нийслэлд шинээр баригдах инженерийн хийцтэй худаг гаргах ажил Дугаар: НХААГ-14/0097
2	хугацаа эхлэх/дуусах	2014.06.15-2014.09.15
3	төсөвт өртөг	178.500.000
4	тухайн онд санхүүжих нь	152.948.464
5	тендер зарлах огноо	2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минут
6	хүлээж авах эцсийн хугацаа	2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минут
7	гэрээ байгуулах эрх олгох огноо	2014.05.19
8	гэрээ байгуулах огноо	2014.05.27
9	гэрээ дуусгавар болгох огноо	2014.09.15
10	шалгарсан оролцогчийн талаарх товч мэдээлэл	“Монтегео” ХХК 2001.06.06-ны өдөр Хүн амын ундны ахуйн хэрэглээний болон ХАА-н бэлчээрийн усан хангамжийн зориулалт бүхий инженерийн хийцтэй гүн өртийн хайгуул, гүн өрмийн худаг гаргах, тоноглох, худгийн тоног төхөөрөмжийн худалдаа, үйлчилгээ хийх үйл ажиллагааны үндсэн чиглэлтэйгээр үүсгэн байгуулагдсан. УБД:9011061142, РД: 2650827
11	гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл	“Монтегео” ХХК-ийн тендерийн материалыг хянаж үзэхэд шаардлагад нийцсэн тендер гэж үзэж байна. Тус компани нь эрх бүхий эсэх, гэрээг хэрэгжүүлэх чадвар, тендерийн иж бүрдэл болон тендерийн баримт бичгийн үндсэн шаардлага зэргийг хангасан шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн байна. Тус ажлыг 160.998.383 төгрөгөөр хийхээр санал ирүүлсэн.
12	шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл	“Тэнхлэг ус” ХХК, “Газрын гүний ус” ХХК, “Буян ус” ХХК, “Эрдэнэ дрийлинг” ХХК, “Ус алмаз” ХХК, “Монгеофизик” ХХК
13	шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл	“Тэнхлэг ус” ХХК “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 27 дүгээр зүйлийн 27.1 дэх заалт, 27.1.3 дэх заалт, 27.4 дэх заалт, “Газрын гүний ус” ХХК, “Буян ус” ХХК, “Эрдэнэ дрийлинг” ХХК, “Ус алмаз” ХХК, “Монгеофизик” ХХК “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.3, 28.7.4 дэх заалт